

ТҮҮХЧИЙН ИНДЭР

**ЧИНГИС ХААН, ИХ МОНГОЛ УЛС,  
МОНГОЛЫН БАЙЛДАН ДАГУУЛЛЫН  
АСУУДЛЫГ СУРГУУЛЬ, СОЁЛЫН АЖИЛД  
ХЭРХЭН ТУСГАХ ТУХАЙ**

**\*Н. Ишжамц**

Бага, дунд, дээд сургуулиудын сурах бичиг, гарын авлагад Чингис хаан, Их Монгол улс, Монголын байлдан дагууллын асуудлыг зарим талаар зөв, зарим талаар дэндүү ташаа тусгаж ирэхдээ гол төлөв улс төр, үзэл суртлын зориулгатай хараан зүхэж, сөрөг ойлголт төрүүлэх чиглэлтэй хандаж байв. Ардчилал, шинэчлэлийн шинэ нөхцөлд асуудлыг үнэн бодит байдлаар авч үзэж, зөв ойлголт төрүүлэх явдал чухал. Үүний тулд урьд баримталж байсан зөв зүйтэй зүйлээ бататгаж, эндүү ташаа зүйлийг залруулан, ерөнхийд нь асуудлыг нааштай байдлаар авч үзэх явдал шаардагдана.

Өнөөгийн байдлаар тухайн асуудалд бүрэн дүүрэн зохих ёсоор хандаж байгаа гэхэд учир дутагдалтай. Хэрэв Чингис хаан, Монголын эзэнт гүрэн, байлдан дагууллын асуудлыг урьд нь хэт өрөөсгөл хараан шүүмжилж байсан бол одоо Чингис хаан ба монголчууд цөм тэнгэр язгууртай, дэлхий дээр хамгийн түрүү соёлжиж, сайн сайхныг дангаар бүтээж, үүрд мөнх ардчилсан байсан юм шиг дэвэргэн ярьж, бас нэг янзын үзэл сурталжсан хэтрүүлэгт нэрвэгдэж эхлэн байна. Энэ бол үнэн байдалд эс нийцэхийн дээр Монголын тухай гадаадад ихээхэн эвгүй сэтгэгдэл төрүүлэн, амьтны элэг доог болгож, эцсийн эцэст эвгүй ганцаардмал байдалд оруулна. Тийм учраас асуудалд зөвхөн шинжлэх ухааны үндэстэй бодит, төв голч, шударга ёсоор хандах нь зүйтэй. Асуудалд бодит байдлаар, ардчилсан ёсоор хандаж байгаа нь энэ хэмээгээд хэрэг дээрээ заавал өрөөсгөл ханадаг архаг хууч болсон солио өвчнөөсөө салж, субъектив хандлагыг эрхбиш эцэс болголгүй горьгүй.

Тэгээд чухам яах ёстой юм бэ? Асуудлын мөн чанар ямар байв, түүнийг яаж ойлгож хэрхэн үнэлж дүгнэх болж байна? гэвэл бидний судалгааны явцад доор дурдсан байдал тодорхой харагдаж байна. Үүнд:

1. XII зууны эцэс, XIII зууны эхээр сүүлийн үеийн Ар, Өвөр, Баруун Монгол, Буриад Монголын нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан Хэрэйд, Найман, Татар, Мэргид, Барга, Буриад, ойрад, Онгуд, Хонгирад, Олхунуд, Киданы зэрэг ханлиг аймгууд цөм язгуурын монгол аймгийн нэгэн адил монгол угсааны, монгол хэлтэн аймгууд байсныг оюутан сурагчдад сайтар ойлгуулах нь чухал. Зарим хүүхэд залуус зөвхөн Хамаг Монголыг л Монгол гэж ойлгоод бусдыг

нь Монгол биш байсан юм шиг ойлголт авсан байдаг нь их л харамсалтай ташаа зүйл болно.

2. Хамаг Монгол гэдгийг нийт Монгол гэж ухаардаг эндүү явдал гардаг. Дээр дурдсан олон Монгол угсааны ханлиг, аймгуудын дунд Хамаг Монгол буюу Монгол гэдэг нэртэй ганцхан ханлиг байсан нь үнэн боловч Хэрэйд, Найман, Татар, Мэргид, Ойрад, Барга, Буриад, Олхунуд, Хонхирад, Онгуд, Кидан цөмөөрөө монгол байсан юм.

3. Хамаг Монголын ханлиг нь Онон, Хэрлэн, Туулын гурван голын эхээр гол төлөв Хэнтийн нуруу, Буйр нуур, Дорнодын хээр талын баруун хойд хэсэгт нутаглаж байсан бөгөөд дотроо язгуурын монгол, дайчиуд, жалайр, Хонхирад, охунуд, жадран зэрэг нэлээд олон аймаг Овгийг багтааж байсан юм. Тэдгээрийн дотроос эрт дээр үеийн Монгол гэдэг нэртэй нэг гол аймаг байсан, түүнийг язгуурын монгол гэдэг байлаа. Язгуурын монголын дотор хинд ясны боржигон овгийнхон зонхилж, чухамхүү тэр овгийн сурвалжит язгууртан нарын дундаас Хамаг Монголын ханлигийн хан сонгогдож гардаг байв.

4. Хияд яс, боржигон овгийнхны өвөг дээдэс нь их эртнийх боловч Хамаг Монголын анхны хан Хабулын гарсан овгийнхныг Хияд ясныхан гэж нэрлэх болсон байна. Хабулын дараа хан суусан Амбагай бол язгуурын Монголтой хос ихэр аймаг болох дайчиуд овгоос гарсан хүн байсан харин түүний дараа хан болсон Хотула бол хийд ясны хүн байв.

5. Чингисийн эцэг Есүхэй баатар бол химд ясны хүн байсан боловч түүний өөрийн удам угсааныхан цөм боржигон овгийнхон гэж ялгаран гарсан юм. Тийм учраас Чингис хаан, түүний удам угсааныхныг боржигон овгийнхон гэдэг. Дээр дурьдсан бүх зүйлээс үзэхэд Чингис хаан бол олон монгол угсааны аймгуудын нэгэн болох язгуурын Монгол аймгийн хияд ясны боржигон овгийн хүн байсан гэдэг ойлголтыг тодруулж мэдүүлэх шаардлагатай.

6. Овог, омог, отог гэдэг гурван нэр томъёоны түрүүчийн хоёр нь тухайлбал овог, омог нь яг нэг ойлголт, хүний цусан төрлийн хамааралтай холбоотой. Отог гэдэг нь цусан төрлийн хамааралтай төдийлөн холбоогүй, дийлэнх ихэнхдээ хуучны хэд хэдэн овог, омгийн нутаг дэвсгэр дээр хөлцөлдөн ижилсэж, засаг захиргааны анхан шатны нэгж болсныг хэлж байгаа гэдгийг сайтар ялгаж салгаж ойлгуулах хэрэгтэй.

7. Жич, XII-XIII зууны монгол нутагт байсан дээрх олон аймаг, овгуудын тухай ярихдаа түүний өмнө яригддаг шивэй, дүнхү, хүннү, сяньби, моюн, тоба, жүжан, түрэг, уйгур, киргис, кидан нартайгаа удам угсаа, хэл соёлын ямар уламжлалт харилцаа хамааралтай байсан тухай тодорхой тайлбарлаж өгдөггүй нь зүйд эс нийцнэ.

Шивэй нар бол Хан Хэнтий, түүний зүүн хойд хэсэг, Хянганы зүүн хойгуур нутаглаж байсан монгол, түнгүс угсааны аймгууд байв. Шивэй нарын нэг хэсэг нь монгол угсааны байсан учир “монгол шивэй” нэртэй байв. Дүнхү нар Хянганы цаагуур байсан монгол, түнгүс угсааны аймгууд, тэдгээрийн зүүн талын хэсэг нь Монгол усааны аймгууд байна. Хүннү нар бол Ар, Өвөр, Баруун Монголын нутгийн төв хэсэгт байсан монгол угсааны 24 аймаг байжээ. Хожмын үед хүннү нарын нэг хэсэг нь Сяньбитай нийлэн ижилсэх, жүжан нарын бүрэлдэхүүнд орсон. Жүжан бол дараачийн үеийн татар нарын өвөг дээдэс байсан бөгөөд тухайн үедээ ч татар гэж заримдаа нэрлэгдэж байв. Түрэг, уйгур, Киргис нар бол монгол биш, түрэх утсааны аймгууд байсан. Гэвч тэд манж нартай адил харийн байлдан дагуулагчид байгаагүй юм. Учир нь Алтайн түрэг бол Монгол нутгийн Алтайн уулс, түүний урьд талаар оршин амьдарч байгаад улс байгуулсны дараа Орхонд төвлөх болсон орон нутгийн уугуул оригин суугчдын нэг хэсэг байв. Уйгур нар бол Сэлэнгийн дунд урсгал, Хөвсгөлийн урд талаар орхин амьдарч байсан уугуул оршин суугчдын нэг хэсэг байв. Киргис хэдийгээр одоогийн Хакас, Абаканд төвлөж байсан боловч эрт дээр цагаас Монголын нэг хэсэг байсаар ирсэн Тува болон Увс нутгаар нэг хэсэг нь амьдарч байсан, зарим талаар бас уугуул орчин суугчдын нэгэн болно. Тэгэхдээ Киргис бол монгол биш, биеэ даасан өөр улс үндэстэн байсныг анхаарч зөв ойлгуулбал зохино. Кидан нар бол дээр үеийн сяньби, моюн, тоба нарын удам угсаанышкан байсан бөгөөд Монголын зүүн өмнөд хэсэг болох Өвөр Монголын Жу-удын чуулган, Ляохэ гол хэмээх зүүн Шар мөрний орчин тойронд төвлөж байсан монгол угсааны аймаг байв. Кидан нарыг Өвөр Монгол, Умард Хятадад Ляо гүрэн байгуулан ноёлжж. байгад Ар Монголд Зүбүлийн 18 аймгийн холбооны хаант улс зонхилж байсан зүбү нарын дунд гол төлөв татар, жүжан утсааны аймаг овог зонхилж байжээ. Зүбү гэдэг нэр нь Хүннүгийн дөрвөн зонхилох овгийн нэгэн болох Скойбу овгийн нэр учир тэдний дунд хүннү угсааныхны удам олон бөгөөд хүчирхэг, зонхилох байдалтай байсан нь илт байна. Хүннү нарын дунд монгол, Хиад гэх зэрэг овог бий болоод байснаас үзэхэд тэд хожмын монголчуудын гол салбарт ижилсэн орсон нь магадтай. XI-XIII зууны эхний Хамаг Монгол, хэрэйд, найман, татар, мэрхид, ойрад, олхунуд, хонхирад, онгуд, кидан зэрэг монгол угсааны аймгуудын хүн амын бүрэлдэхүүнд шивэй, дүнхү, хүннү, сяньби, жүжан нарын ихээхэн хэсэг тархан оролоод байсны дээр зүүн түрэг, уйгур, киргис нарын дотроос Монголд үлдсэн зарим хэсэг буюу зарим хүмүүс бас ижилсэж орсон байв. Энэ бүхнийг сайн мэдэх явдал бол нийт монгол угсаатан, үндэстэн хаана, хэзээ, хэрхэн үүсч бүрэлдсэн тухай асуудлыг бүрэн дүүрэн ойлгоход чухал юм.

8. Сүүлийн жилүүдэд Чингис хааны мэндэлсэн он цагийн талаар дотоод, гадаадад янз бүрээр ярих болов. Урьд нь ч гадаадад янз бүрээр

ярьдаг байсан юм. Бүх монгол, Төвд түүхэн сурвалж болох хятад судрын дийлэнх олонхид Чингисийг усан морин жил буюу 1162 онд төрсөн хэмээн тэмдэглэсэн байдаг тул тэр нь маргаангүй зөв гэсэн бүрэн болно. 1962 онд Чингисийн мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэжтэй уялдуулж, Академийн Түүхийн хүрээлэнгийн эрдэмтэд, Гандан хийдийн зурхайч нар тусгайлан хамтарч ажиллаад түүнийг 1162 оны 5 дугаар сарын 31-нд төрсөн болохыг товлон тодорхойлоод ойн хурлыг 1962 оны 3 дугаар сарын 31-нд хийж, Үнэн сонин зэрэг төвийн хэвлэл, мэдээллийн шугамаар тэр өдөр тусгай зориулга бүхий өгүүлэл, нэвтрүүлэг явуулж, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн юм.

Уг асуудлыг тийнхүү шинжлэх ухааны үндэстэй товлон тодорхойлж, ойг албан ёсоор тэмдэглэн өнгөрүүлсэн 5 дугаар сарын 31-ний өдрийг одоо элдэв янзаар эрэгцүүлэн өөрчлөх оролдлого хийх нь бүтэшгүй бөгөөд олон улсын талбар дээр маш зохимжгүй юм. Тийм учраас энэ асуудлыг дахин будлиантуулахгүйн тулд Чингис хааны төрсөн он цагийг ялангуяа сургууль, соёлын байгууллагуудад нэг метри 1162 оны 5 дугаар сарын 31 гэдгээр нь үлдээж, төлөвшүүлэн тогтоож авах явдал чухал. Энэ явдал Чингисийн ойг хойшид дотоод, гадаадад тэмдэглэх, олон улсын талбар дээр энэ талын үйл ажиллагаа явуулах зэрэгт ч тодорхой байлгах түүхэн ач холбогдолтой болохыг сургууль, соёлын байгууллагууд анхаарч ажиллах нь зүйтэй болов уу.

9. Чингис хаан бие бялдар, төрх байдал, зан чанарын хувьд ямархуу хүн байв гэдгийг хүмүүс зүй ёсоор ихэд сонирхдог боловч газар бүрд цагийн аяыг дагаж янз янзаар дүрсэлж ирсэн. Бидний судалгаанаас үзэхэд Чингис хаан бол үл мэдэг зуувандуу дугариг нүүртэй, улбар шиг бор шаргал царайтай, хундан шаргал туяа бүхий хар үс, сахалтай, үс сахалдаа ургамлын тослог улаан шүүс түрхэж, сүр оруулан ариутгаж явдаг, цайвардуу бор хүрэн нүдтэй, ирүүн хурц харцтай, нэлээд өндөр биетэй, мөр, цээжээр өргөн, бэлхүүс бүсэлхий нарийн, дунд зэргийн арга бүхий, туранхай үгүй хүн байжээ. Хөлийн хэмжээ хараахан тодорхойгүй боловч биеийн тэнхээ нь дүү Хасар, Бэлгүдэй нарынхад хүрэхгүй, дунд зэрэг байжээ. Сэлэм жад, зэр зэвсэг эзэмшихдээ сайн байсан боловч тухайн үеийн бусад идэрхэг чийрэг баатар эрсийнхээс төдийлөн давуу байсангүй, эрүүл мэндийн хувьд харин хэнээс нь ч дутуугүй чийрэг бегеед биеийн эсэргүүцэл маш сайн байжээ. Чингис хаан бол бүх талаар өв тэгш сайн сайхан, өчүүхэн ч дутагдалгүй, ариун нандин шүтээн байв уу гэвэл огтхон ч тийм биш нь мэдээж хэрэг. Тэр бол бурхан ч биш, чөтгөр шулам ч биш, жирийн л нэг монгол сурвалжит язгууртан хүн байсан. Бага залуудаа өөр эхээс төрсөн Бэгтэр ахыгаа төрсөн дүү Хасартай нийлж хороох зэргээр эшийн санаа сэтгэлийг хамгийн их зовоож түгшүүлсэн айхтар хүүхэд байсан. Гэвч сүүлийн үед Зөвлөлтийн нэрт дорно дахинч Л. Гумилев зэрэг эрдэмтэд Бэгтэрийн алуулсныг дайчиуд, мэргидийн зэрэг Тэмүүжиний өшөөтөн дайсны тагнуулч туршуулч

болсны улмаас үүдсэн хэрэг гэж үзэх болсон нь бүрэн нотолгоогүй боловч бас байж болох зүйлийн нэг ажээ.

Чингисийн бусдаас хэтийдсэн гарамгай чадал нь түүний амьдрал тэмцэлд ямаг оюун билгийн суут эрчим хүчин, төрийн бодлого, цэргийн эрдмийн гарамгай авьяас чадвар, ёс суртахуун, шударга ёс, хүн чанарын нандин шинж, бусдын чанар чансааг харангуут танин мэдэх нарийн нууц увидастай байсанд оршино. Чингис хэдийгээр язгуурын Монголын хияд ёсны боржгин омгийн хаан язгуурт томоохон сурвалжтан баатрын гэр бүлд төрсөн боловч хар багаасаа хал үзэж, хамгийн ядуу зүдүү хүний хувь тавиланд удтал өртөн амьдарч зовлон үзсэн болоод ч тэр үү, эсвэл төрөлхийн ухаалгийн учраас ч тэр үү, ямар боловч хоол, хувцас, орон сууц, эд баялаг, эмс охид, эд хөрөнгө, жаргал цэнгэлийн алинд ч шунан даврах хомхой сэтгэлгүй, ямарч хүнд нөхцөлд санаа сэтгэлээр унаж гэж үгүй, харин ч улам ухааран чангардаг сонин хүн байв. Ерөнхийдөө анхнаасаа нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой айхтар хүний шинж бүрдсэн хүн байсан бөгөөд тэр нь хүний хань нөхөд, өстөн дайсны аль алинд балчир цагаас нь эхлэн тодорхой ажиглагдаж байж, нөхдийн бахдал, дайсны хорслыг төрүүлж байсан боловч тэр өөрөө үндсэндээ даруу төлөв, төв голч, үнэнч шударга хүн байв. Түүнд тийм их дээрэнгүй, омог бардам зан, онгирох сагсуурах явдал, ерөөсгөл хэтрүүлгийн хандлага огт байсангүй, нэг үгээр хэлэхэд төрөлхийн төрийн бодлогын их хүн, цэргийн эрдмийн суут авьяастан, дипломатын ба тагнуулын ажил удирдаж зохион байгуулах онцгой чадвартай байж билээ.

Чухам энэ бүхний улмаас 1189 онд Хамаг Монголын хан, 1206 онд Их Монгол улсын хаан болоод дараа нь бас Монголын эзэнт улсыг байгуулж, түүний эзэн хаан болтол нүүдэлчин нэг Монголын хэрээс хэтэрсэн үйл ажиллагаа өрнүүлж, Монгол гэдэг нэрийг ертөнцийн чихнээ дуурсган Монгол улсыг дэлхийн олон улсын талбар дээр баттай гаргаж ирж чадсан хүн билээ.

10. Чингисийн үед Их Монгол улсын амьдрал, хөгжилд дан ганц дарангуйлал ноёлж байсан гэж үздэгийн адил бас ардчилал зонхилж байсан гэж үзэх үндэс алга. Их Монгол улсад Чингисийн үед төр ёсны дарангуйлал дээдлэгдэж байсан боловч ардчилал, шударга үнэнчийн ёс, хүнлэг ёсны зарим зүйл дээгүүр, доогуургүй эрхэмлэгдэж байв. Чингисийн үе бол ардчилал, үнэн шударга хүнлэг ёс бүхий төр ёсны хатуу боловч шударга дарангуйллын үе байсан юм.

11. Чингис хаан хэрхэн Хамаг Монголын хан, Их Монгол улсын хаан болоод харь орнууын эсрэг ямар байлдан дагуулал явуулсан зэргийг хуучин сурах бичиг, гарын авлагуудад ч тодорхой бичсэн тул тэр тухай энд нэмж нурших шаардлагагүй. Тэдгээр зохиолд Хамаг Монголын нэгдлийг сэргээж, улмаар нийт Монгол угсааны аймаг,

ханлигуудыг нэгтэн Монголын нэгдсэн улсын байгуулсан нь дэвшилттэй үйл хэрэг байсан, түүнээс гадна тэр явдал нь Монголын тухайн үедээ дэвшилттэй байсан феодалын ёс бүрмөсөн ялан давамгайлж, Монгол орон жинхэнэ нүүдлийн феодалын улс болж, Монгол угсаатан бүрэлдэн тогтоод Монголын нүүдэл иргэншил шинэ шатанд гарч хөгжсөн тухай зөв зүйтэй цохон тэмдэглэсэн байгаа, тэр бүх үнэлгээ дүгнэлт хүчин төгөлдөр хэвээр үлдэх ёстой. Нэмж хэлэх ёстой нэг зүйл бол Чингисийн үед Монгол угсаатан төдийгүй, нэгдмэл Монгол үндэстэн бүрмөсөн бүрэлдэн тогтоод хожмын хэд хуваагдсаныг эрхбиш тодорхой дурьдан ярих нь зөв болно. Яагаад гэвэл үндэстэн бол зөвхөн капитализм, социализмын үед биш, ангит нийгэм, нэгдсэн төр улс үүсмэгц бүрэлдэн тогтдог зүйл. Тэгэхлээр Чингисийн үед Монгол үндэстэн угсаатан бүрэлдэн төлөвшсөн гэж заах нь зүйтэй. Чингисийн байлдан дагуулал нь бусад улс орны төрийг мөхөөж, хүн ардыг хядаж, эдийн засаг, соёлд ихээхэн хор хохирол үзүүлсэн тухай санаа дүгнэлт үндсэндээ хүчин төгөлдөр хэвээр үлдэх ёстой. Энэ талаар бид Чингисийн үйл ажиллагааг хэт цагаатгах гэвэл үнэн байдал, шударга ёсонд эс нийцээд олон улсын талбар дээр биднийг эвгүй байдалд оруулах сөрөг талтай гэдгийг эрхбиш санах, хэрэгтэй.

13. Сурах бичиг, гарын авлага, Монгол, Зөвлөлтийн олон зохиолд Чингисийн байлдан дагуулал нь монголчуудын хүчийг дайн дажинд тарамдуулж, ард түмний аж байдлыг доройтуулан, эдийн засгийн хөгжилд нь саад тотгор учруулж, түүгээрээ Монгол орны өөрийн хөгжилд хор хохирол учруулсан гэсэн зүйл цохон тэмдэглэгдсэн байдаг нь түүхийн үнэн бодит байдалд үл нийцнэ. Манай түүхчид үүнийг сайн мэдэж байсан боловч 1949 оноос эхлэн аргагүй үзэл суртал, улс төрийн шахалтанд орж, тийм буруу ташаа зүйлийг мэдэн байх эс мэдэгчийн дүр үзүүлж даган дууриаж бичдэг болсон юм. Тэгээгүй, үнэнийг хэлэх гэсэн эрдэмтэн мэргэд маань цөм феодалын ёсыг магтаж, харгис байлдан дагууллыг магтан дуулж, хөрөнгөтний үндэсний үзэл гаргасан хэрэгт холбогдож хэлмэгдэх болсон билээ.

Үнэн хэрэг дээрээ Монголын нэгдсэн төр улс байгуулагдаж, нүүдлийн феодалын ёс, монгол угсаатан үндэстэн бүрэлдэн тогтох эгзэгтэй нөхцөлд ялгуун байлдан дагуулан явуулсан нь Монголын хөгжил дэвшилд тус дөхөм болоод монголчуудын амьдрал байдлыг сайжруулснаас биш, өчүүхэн төдий ч доройтуулаагүй.

Чингис хаан байлдан дагуулал явуулж монголчуудыг энд тэнд цацан-тараасан гэдэг худлаа. Чингис байлдан дагуулсан улс оронд цөөн тооны монгол захирагч суулгаад гол төлөв нэг эзлэгдсэн орны нөгөө эзлэгдсэн орны цэрэг, дарга нарын хүчээр дарангуйлан барьж байсан бөгөөд мөн эзлэгдсэн орны дагаар орсон төр, цэрэг, иргэний зүтгэлтэн, олон улсын худалдаачид, шашин мөргөлийн үйлстэнд түшиглэн ажиллаж, амжилт олж байсан юм. Чингис, Өгөдэй, Гүюг,

Мөнх нарын зэрэг Монгол гүрний анхны их хаад өөрийн орны цэрэг, иргэдийн хүчийг харь оронд урт удаан хугацаагаар цацан тарамдуулж, улс төрийн төвийг гадаадын ямар ч өндөр хөгжилтэй, амьдрал сайжирсан сайхан оронд түр буюу заримдаг байдлаар ч гэсэн шилжүүлж хэрхэвч үл болохыг хэнээс ч дутуугүй сайн мэдэж байсан юм.

Чингисийн үед бас Оросыг байлдан дагуулж, Оросод нэг их хор хохирол үзүүлсэн юм шиг ярьдаг, бичдэгийг бас залруулах шаардлагатай. Чингис өөрөө Оросын хилд хэзээ ч хүрч байгаагүй, харин Зэв, Сүбээдэй хэмээх хоёр өрлөг жанжин нь хориодхон мянган морьт цэрэгтэйгээр найман, мэргэдийн эрх баригчдын ширээ залгамжлах хөвгүүдийг нэхэж гараад Хорезмын дайнд оролцон буцах зам зуур хойш эргэж Оросын зах хязгаарт дайснаа мөрдөн хүрч очтол Оросын вангууд дайсан довтоллоо хэмээн сүр бадруулж, хүч хавсран дайрч байлдаад дийлэлгүй цохигдсон байдаг. Зэв, Сүбээдэй нар Оросыг довтлох даалгавар ч үгүй, зорилт ч үгүй явсан бөгөөд Оросын вангуудын цохигдож зугтсаных нь дараа ч тэднийг нэхэж байлдалгүй, нутгийн зүг хөлгийн жолоо залсан түүхтэй. Хожмын үед Оросын вангууд эе эвээ хичээж, хүчээ нэгтгэж, олигтой эсэргүүцэн тэмцэлгүй Чингисийн ач хөвгүүн Батын цэрэгт цохигдон эзлэгдсэний ялыг Чингисийн нуруун дээр тохох нь түүхэн үнэн, шударга ёсонд эс нийцнэ.

14. Чингис хаан болон түүний дараачийн монгол хаадын байлдан дагуулал нь Ази, Европын олон улс орны хувьд ихээхэн хүнд дарамт болж, олон хүний амь насыг бүрэлгэн, эдийн засаг, соёлын үнэт зүйлсийг ихэд сүйтгэсэн сөрөг талтай нь үнэн, тэр тухай дээр дурьдсан.

Гэсэн ч одоо зааж байгаа хичээл, гаргаж байгаа соёл, урлагийн бүтээлд монгол хаад, жанжин нар, Монголын байлдан дагууллыг зөвхөн ганц дан харгис бурангуй үзэгдэл байсан мэт харуулж болохгүй. Учир нь Монголын байлдан дагуулал бол эрт, эдүгээгийн бусад бүх байлдан дагууллын нэгэн адил дийлсэн нь ялж, дийлдсэн нь ялагдаад, “дийлсэн нь хаан, дийлдсэн нь хулгай” гэгчийн үлгэр загвараар явагдаж өнгөрсөн зүйл. БНХАУ, Япон, Өрнөдийн эрдэмтэд болон Зөвлөлтийн Владимирцов, Гумилёв нарын зэрэг томоохон монголчдын нотолж байгаагаар Монголын байлдан дагуулал нь бусад улс орны байлдан дагууллаас илүү харгис зэрлэг байсангүй, Чингис хаан ч үнэндээ тийм сүрхий балмад этгээд байгаагүй ажээ. Чингис хаан бол цэрэг дайны үед ялж гарахын хэмжээгээр байлдааны зохих үйл ажиллагаа явуулахаас биш, ямарваа хэрэгцээ шаардлагагүй зэрлэг балмад алан хядлага, эвдрэл сүйтгэл учруулдаггүй байсан тухай тэд цохон тэмдэглэсэн байдаг.

Чингис хаан Монголынхоо төр ёс, Монголын нүүдлийн ахуй амьдрал, хүн ардынхаа зан суртахууныг эрхэмлэн дээдэлж, гуйвалтгүй дагаж мөрддөг байсан боловч бусад орны шашин, төрийн ёс, ахуй амьдралын хэв загвар, зан суртахууныг нүд үзүүрлэн гадуурхдаггүй, ихээхэн уужуу сэтгэлтэй, ухаалаг төрийн бодлоготон байсан юм. Монголын төрд үнэнч зүтгэхээр зориг нулуудсан хүнийг Чингис хаан яс үндэс, угсаа гарал, шашиг шүтлэг, баян ядуу, нүүдэл суурьшлын гэж огтхон ч ялгаагүй ил сонгон авч, түшиглэн дэмжиж хэрэглэдэг байв. Энэ нь Монгол гүрнийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан талтай.

Монголын байлдан дагууллын явцад эзэнт гүрний нийслэл, улс төрийн төвийг Хархорумаас Бээжинд шилжүүлсэн явдал эцсийн эцэст Хятадад ач тусаа өгөөд Монголдоо сөрөг нөлөө үзүүлсэн талтай. Юан улсын хаадын гол анхаарал гүрний нийслэл Бээжин, дэд Нийслэл Шанду хотыг тохижуулахад хандаад Монголын эрдэмтэн мэргэд, төрийн зүтгэлтний олонхи нь Бээжинд суух болсон учир Хархорум ба нийт Монгол орны амьдрал, хөгжлийн асуудал зарим талаар орхигдон гээгдсэн байдалтай болж, алсдаа муу нөлөө үзүүлсэн байна. Гэхдээ тэр учир Хубилайг урвагч этгээд байсан гэж үзвэл арай ч эс зохих. Хубилай гүрний нийслэлийг Хятадад шилжүүлэхдээ нийт Хятад ба Зүүн өмнөд Азийг эзэлж, эрх мэдэлдээ баттай барьж үлдэхийг бодсон хэрэг. Тэр зорилтоо Хубилай амжилттай биелүүлж, санасан санаандаа үндсэндээ хүрсэн боловч Монгол орныхоо цаашдын улс төр, эдийн засаг, соёлын тууштай хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхийг тооцож, урьдчилан харсангүй гунигт явдал болсон юм.

Юан улс даяар, түүний гол хэсэг болсон Хятадад ноёлох, Хятадын баруун өмнөд хязгаарыг сахин сэргийлэх зорилгоор олон Монгол-цэргийг гэр бүл, мал сүргийнх нь хамт нутаг шилжүүлэн тэнд аваачиж суулгасан нь Юан улсын мөхсний дараа тэнд орхигдон үлдэж, хятад, и үндэстэн зэрэгтэй ижилсэн ууссан байна. Одоогийн Хятадын баруун урд талын Юньань мужид Хубилайн цэрэг, иргэний 200 мянгаад монгол хүн үлдсэн нь тарж бутарч, Хятад, и үндэстэнд ижилсэн уусаад одоо дөнгөж 10 мянга хүрэхгүй хүнтэй, цагаан будаа тарьж амьдардаг таван тосгон болок үлдээд байгаа. Тэдний хэл ярианд монгол үг байвч хэл нь үндсэндээ зэргэлдээх и үндэстний хэлэнд ижилссэн байгаа. Сонирхолтой нь тэд тэр хэлээ одоо болтол монгол хэл гэж үзэж, өөрсдөө өвөр хоорондоо монголоор ярьж байна гэж боддог ажээ. Төв Хятадын Хэнань мужид бас Юан улсын монгол дарангуй цэргийн нэлээд олон баг үлдэж, Хятадтай ижилсэн ууссан тосгон борж үлдээд байна. Хятадын Ганьсу, Хятад-Түвдийн Хөх нуур мужид дэд монгол, монгор, шарай гол, шар уйгур зэрэг монгол хэлтэн аймаг ястангууд байгаа нь бас Юан улсын монгол цэрэг, иргэний үлдмэр дом. Ер нь Юан улсыг мөхөхөд 40 түмэн монгол, 4 хэн ойрад байсны зөвхөн зургаан түмэн монгол, дөрвөн түмэн ойрад Монгол нь нутагтаа үлдээд бусад 34 түмэн монгол нь Хятадад

хаагдан үлдэж, аяга болсон гэсэн зүйл түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Мөн Иран, Дундад Ази, Оросын цөөн боловч хэдэн хэсэг монголчууд үлдэж, нутгийн хүмүүстэй ижилсэн уусч алга болсон. Афганистанд ч одоо болтол Монголын эзэнт гүрний дарангуй цэрэг, тэдний гэр бүлээс үлдсэн, эртний монголоороо ярьдаг хэсэг тосгон бий. Иранд хар татар, Оросод татар нар гэж байгаа нь цөм монгол биш боловч татар гэж нэрлэгдэж байсан цөөн тооны монголчуудын эрхшээл доор захирагдан байгаад монголчуудыг өөртөө ижилсүүлэн уусгасан иран, баруун түрэг угсааныхан болно. XIII зуунаас хэдэн зуун жилийн өмнө Унгарын зүүн хэсэгт бас татар хэмээх нэртэй хэсэг өөр угсааны хүмүүс байсан нь Монголын байлдан дагууллын үед очсон бус, харин жүжан угсааны авар нарын YI-YII зууны байлдан дагууллын үед очоод үлдсэн хүмүүс байв. Жүжан нар татар угсааны хүмүүс байсан тухай дээр дурьдсан бөгөөд тэр эрт дээр үед ч гэсэн өөрсдийгөө заримдаа татар хэмээн нэрлэж байсан тул Унгарт үлдсэн жүжан, авар хүмүүсийн нэг хэсэг нь татар гэдэг нэрээ хадгалж үлдээд байсан хэрэг. Аливаа урт удаан хугацааны байлдан дагуулал, удтал оршин тогтносон их эзэнт гүрний ноёлогч угсаатан ястны нэлээд хэсэг нь тийнхүү харь оронд цацагдаж, эх нутгаасаа бүрмөсөн ангижран харь угсааны хүн амын дунд ижилсэн уусдаг явдал байдаг, тийм байдалд ч тэдгээр монголчууд орсон байна. Тийм учраас Чингисийн байлдан дагууллын үед биш, харин дараачийн хаадын байлдан дагууллын үед нэлээд монгол хүн харь оронд цацагдан уусч алга болсон гэвэл үнэн байдалд илүү нийцсэнэ. Энэ талаар Чингисийн дараах хаадын байлдан дагуулал нь Монголдоо халгаатай болсон явдал үнэхээр бий.

Монголын байлдан дагуулал нь Монгол ба эзлэгдсэн орнуудад сөрөг нөлөө үзүүлсэн ч эерэг нөлөө үзүүлсэн олон талтай. Тэр бүхнийг улам улмаар нарийвчлан судалж, жигнэж дэнслэх нь бидний зорилт. Ямар боловч Монголын эзэнт гүрэн, Их Монгол улс бол тухайн үедээ одоогийн АНУ, саяхны ЗХУ-ын нэгэн адил дундад эртний хамгийн том бөгөөд хүчирхэг хэт их гүрэн байсан нь гарцаагүй. Тэр талаас нь авч үзсэн ч Монгол улс, монгол үндэстэн бол хэрхэвч бага буурай улс, үндэстэн уг нь би байв гэлтэй.

Монголын байлдан дагууллын явц, Монголын эзэнт гүрэн байгуулагдсаны дараах дотоод, гадаад улс төр, эдийн засаг, соёлын харилцааны өрнөлтийн үр дүнд хамгийн наад зах нь Монголын байлдан дагуулал, эзэнт гүрний оршин тогтнох хугацаанд Орос, Хятад, Иран, Дундад Азийн улс орон тус бүрийн нэгдмэл байдал сэргэж батжаад Монгол, Орос хоёр бие биеэ сайн мэддэг болсон, Монгол, Европын улс түмний хооронд тал бүрийн харилцаа холбоо бий болж, харилцан мэдэлцэх болсон буй. Тухайн үед Монголоор бий дамжин Ази, Европын хооронд улс төр, худалдаа-эдийн засаг, соёл иргэншлийн өргөн харилцаа тогтож, олон улс орон дамжиж, тив

дамнасан алс холын их замын харилцаа холбоо бий болсон байна. Дэлхийн гурван их шашин, хүн төрөлхтөний гурван их арьстан, олон үндэстэн угсаатан, овог аймгуудын хүмүүс нүүр учирч, харилцаа холбоо, хамтын ажиллагаа тогтоон улмаар ихэд найрамдан ижилсэж ирсэн байдаг. Чухам тэр үед өрнө дорно, өмнө умрыг холбосон торгоны их замын үйл ажиллагаа бүх талаар дээд цэгтээ тултал өрнөн дэлгэрсэн байв.

Энэ бүхний улмаас урьд нь аян дайны хөлд нэрвэгдсэн Ази, Европын олон улс орон шинэ үндсэн дээр сэргэн хөгжиж, дахин урагшлан мандах суурь тавигдсан байдаг. Монголын эзэнт гүрэн нурсны дараа Хятад, Орос, Иран, Дундад Ази болон Дорнод Европын зарим улс орны нэгдмэл байдал батжиж, улс төр, эдийн засаг, соёлын хөгжил түргэссэн нь зөвхөн Монголын ноёрхлыг устгасны үр дүн биш, харин тэрхүү ноёрхлын үед нэгэнт аажим бэлтгэгдэж, нөхцөл бүрдэгдсэний ачаар тийм болсон хэрэг хэмээхэд бүрэн болно.

Тийм учраас Монголын байлдан дагуулын хор хөнөөлийг үгүйсгэлгүй тэмдэглэж ярихдаа ч гэсэн дээр дурдсан утга учир, ач холбогдол бүхий зүйлсийг анхаарч, эрхбиш эхийг эшээж, тугалыг тураахгүй байхыг сургалт хүмүүжил, соёл урлагийн туурвил бүтээлд зохих ёсоор анхаарч ханддаг болох явдал зайлшгүй шаардлагатай чухал зүйл болоод байна.

Чингис хаан, Их Монгол улс, Монголын байлдан дагуулын асуудлыг бодит байдлаар үнэн зөв тавьж, тусган ажиллах нь улс төр, олон улсын харилцаа, үзэл онол, ёс суртахуун, хүмүүжил боловсролын олон талын чухал ач холбогдолтой билээ. Тийм учраас ардчилал, шинэчлэлийн орчин үеийн нөхцөлд тухайн асуудлыг зохих ёсны хэмжээ, түвшинд зөв зүйтэй тавьж уламжлан төлөвгүүлэх явдал эрхэм зорилт болж байгаа юм.

МОНГОЛ ДАХЬ ӨӨРЧЛӨН  
БАЙГУУЛАЛТ

**ХАНДИВЛАГЧ ОРНУУД БА  
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХУЧИН ЗҮЙЛ  
ТҮҮНИЙ ТӨЛӨВ**

**Ч. Ганзориг**

Нэг. Эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Монгол орон сүүлийн хэдэн арван жилийн туршид чиг баримжаагаа болгож ирсэн нийгмийн байгууллын хэв загвараас татгалзаж, ардчилал, чөлөөт эдийн засаг, гадаад харилцааны нээлттэй бодлогын

\*Ч. Ганзориг-Үндэсний Хөгжлийн Газрын Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга